



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2021 оны 01 сарын 13 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Арилжаалагдаагүй баталгаат үнэт цаасыг
төвлөрсөн хадгаламжийн бүртгэлээс хасах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “МИК актив арван найм ТЗК” ХХК-ийн нэр дээрх 24,642 ширхэг, “МИК актив арван ес ТЗК” ХХК-ийн нэр дээрх 35,098 ширхэг, “МИК актив хорь ТЗК” ХХК-ийн нэр дээрх 33,361 ширхэг, “МИК актив хорин нэг ТЗК” ХХК-ийн нэр дээрх 79,157 ширхэг, “МИК актив хорин хоёр ТЗК” ХХК-ийн нэр дээрх 70,022 ширхэг, “МИК актив хорин гурав ТЗК” ХХК-ийн нэр дээрх 24,358 ширхэг, “МИК актив хорин дөрөв ТЗК” ХХК-ийн нэр дээрх 21,260 ширхэг баталгаат үнэт цаасыг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлээс хасахыг “ҮЦТХТ” ХХК /Ж.Байгалмаа/-д үүрэг болгосугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА  Д.Б. ЯРСАЙХАН